

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

Н. Ариунгуа

ХЯТАДЫН ЦАГААН ХЭРЭМ

Хятадын Цагаан хэрэм нь нүүдэл суурьшмал хоёр ертөнцийн зааг, хоёр өөр соёл иргэншлийн зааг, олон мянган жилийн турш бие биеэ дааж ангид тустай оршиж байсан ард түмнүүдийн харилцааны түүхийн гэрч баримт юм. Хятадын Цагаан хэрэм нь 2000 гаруй жилийн түүхтэй билээ.

Манай эриний өмнөх IV—III зууны үед Монгол нутагт оршиж байсан аймгууд мал аж ахуй дагнан эрхэлж байв. Нүүдлийн мал баж ахуй, зарим газраар хөгжиж байсан газар тариалагийн аж ахуй тэр үеийн нүүдэлчдийн хэрэгцээг тэрчлэн хангаж чадахгүй байсан учир нүүдэлчид хөрш зэргэлдээ хятад улсын газар тариалангийн бүтээгдэхүүнийг олж авч хэрэгцээгээ хангахыг чухалчилж байжээ. Хятад нүүдэлчдийн бараа таваараар гачигдаж байгаагүй ч гэсэн тэдгээрийг олж авч хэрэглэх нь эдийн засгийн хувьд ашигтай байв.

Хоёр тал өөрсдийн хэрэгцээт зүйлийг худалдаа солилцооны замаар авч байсан боловч тэрхүү найрамдалт харилцаа удаан хугацаагаар үргэлжилж чаддаггүй байв.

Хятадын тал нүүдэлчдийг бараа таваараар гачигдуулж эдийн засгийн хавчлага үзүүлж байсан ба нүүдэлчид хятад руу довтолж өөрсдийн хэрэгцээт зүйлийг хүчээр авч байжээ. Хойт зүгийн нүүдэлчдийн довтолгооны тухай хятадын сударт олонтаа тэмдэглэжээ. «Нүүдэлчид өдрөөс өдөрт олшрон улмаар мал аж ахуй, ан гөрөө тэдний хэрэгцээг хангахаа больжээ» гэж хятадын эртний сударт нүүдэлчдийн довтолж байсан шалтгааны талаар бичсэн байдаг.

Нөгөө талаас Монгол нутагт оршин амьдарч байсан нүүдэлчин аймгууд төмрийн түрүү үед шилжин орсноор үйлдвэрлэх хүчний хөгжил болон үйлдвэрлэлийн харилцаа, нийгмийн байгуулалд өөрчлөлт оруулахад хүргэж овгийн байгууллын задралыг гүзгийрүүлэн, овгийн сурвалжтан—ноёлог хэсгийг бий болжээ. Тэдгээр овгийн сурвалжтан нар өөрийн өмч хөрөнгийг баяжуулах, эзэмшилт газраа өргөжүүлэн тэлэх зорилгоор гадагш довтолж байв. Хятад улс нүүдэлчдийг номхрулан дарж тэднийг эрхшээлдээ оруулахыг хүсэж байжээ. Монгол нутагт оршин амьдарч байсан нүүдэлчид болон хятад улс хоёрын түүхэн харилцааны үндсэнд оршиж байсан эдийн засаг, улс төрийн ийнхүү нөхцөл нь тэдгээрийн хооронд үргэлжилж байсан дайн дажныг үүсгэж байв.

МЭӨ III зуунд хятадын эзэн хаад хойд зүгийн нүүдэлчдээс өөрсдийгөө хамгаалах зорилгоор Цагаан хэрэм барихад хүрсэн гэдэг.¹ Гэвч Зөвлөлтийн зарим нанхиадач зэрэг бас бус эрдэмтэд Цагаан хэрмийг барьсан шалтгааныг нүүдэлчдийн довтолгооноос хамгаалахаас гадна хятадын дарлагдсан ард түмэн газрын эздийн эсрэг тэмцэлдээ нүүдэлчин аймгуудыг түших гэсэн эрмэлзлэлийг хориглох гэсэн давхар зорилго хадгалсан гэж үздэг юм.

¹ История МНР. М, 1983, с. 95

Цагаан хэрмийг барих ажил эртний хятадын Цинь улсын үед (мэ 246—207) ид өрнөж байсан тухай олон судар бичигт тэмдэглэсэн байдаг.² Цинь улсын эзэн хаан Цинь Шихуан хойт зүгийн нүүдэлчидтэй тэмцэхийн тулд урьд өмнө баригдсан зах хязгаарын салангид тусгаар хэрмүүдийг залган 4000 гаруй км урт Цагаан хэрэм бариулжээ. Цагаан хэрмийг дайнд олзлогдогсад, Цинь Шихуаны харгис дэглэмийг эсэргүүцэж байсан боолчууд, тариачдын зэрэг энгийн олон хүн, Кунзын сургаалийг баримтлагчдын хүч хөдөлмөрөөр босгосон байна. Тэд хүнд хүчир ажлыг ажлыг дийлэхгүй олон зуу мянгаараа үхэж байжээ. Хятад улс нүүдэлчдийн довтолгооноос хамгаалах нэрийдлээр хэдэн мянган км үргэлжилсэн урт хэрэм барьсан боловч тэр хэрмийг сахин хамгаалахын тулд асар их хэмжээний цэргийн хүч, хоол хүнс зарцуулах шаардлагатай байсан учир улсын хувьд дааж давшгүй хүчир зүйл байв.

Хятадын Хан улсын цэргийн жанжин Янь Ю (мэ 9 он) Шихуаныг шүүмжлэн ингэж бичсэн байдаг: «Цинь улсын эзэн хаан Шихуан ард түмний хүчийг үл тоомсорлон 10 мянган ли газар үргэлжилсэн хэрэм байгуулсан бол боловч тэрхүү хил хязгаарын бэхлэлт нь Дундад улсыг доройтуулан, эцсийн бүлэгт Цинь улсыг мөхөөжээ»³.

Хятадын Цагаан хэрэм ингэж эрт дээр үеэс Хятад болон нүүдэлчин ард түмнүүдийн хооронд хилийн бэхлэт болж байв. МЭӨ 198 онд хятадын Хан улсын хаан Гаоди, хүннү гүрний Шаньюй хаан нарын байгуулсан гэрээнд Түмэн газрын Цагаан хэрмээс хойшхи газрыг хүннү нарын хаан захирахыг Хан улс зөвшөөрсөн ба хэрмээс урдах газрыг хятадын хаан захирах эрхийг хүннү улс зөвшөөрчээ. Энэ тухай Хан улсын нэгэн айлтгалд бичсэн нь: «Урт хотоос (Цагаан хэрэм) хойш нум барьсан улс Шаньюйн цаазыг дагасугай, урт хотоос хотоос дотогш дээл малгайн улсыг би захирсугай»⁴ гэжээ.

Хятадын улс түүхийн урт хугацаанд энэхүү хилийн бэхлэлтийг нэмж барьж, нурсан хэсгийг нь засварлаж байсан байна.

Тухайлбал XII зууны эхээр монгол аймгуудыг хүчирхэг болоход Цагаан хэрэмний бэхлэлтийг чангалж, шороогоор хийгдсэн хэсгийг чулуугаар өөрчилөн барьсан байна. Мөн Мин улсын үед цагаан хэрэмний бэхлэлтийг чангалж нэлээд хэдэн цайз нэмж барьсан нь тэр үеийн хятад-монголын харилцаа хурцадмал байснаар тайлбарлагдах юм. Мин улс нүүдэлчдийн эсрэг явуулж байсан хятадын хаадын уламжлалт түрэмгий бодлогыг идэвхтэй сэргээн явуулж байв. Хан улсын үед хүннү нарын эсрэг явуулж байсан «И и чжи и» (нүүдэлчдийг ашиглан нүүдэлчдийг довтолох), «Цаньши» (Хүр хорхой адил бусдын нутгийг идэх) зэрэг уламжлалт тактикийг хэрэглэхийн хамт нүүдэлчин ард түмнүүд суурьшмал ард түмний бараагаар үргэлж дутагдаж байдгийг мөн ашиглан тэдэнд эдийн засгийн хавчлага үзүүлж худалдаа хийхийг татгалзаж байжээ. Энэ нь монголын феодалуудаас Мин улсын эсрэг дайн байлдаан хийхэд хүргэж байв. Уг дайн нь Мин улсын түрэмгий бодлогын эсрэг мөн уг бодлогын бүрэлдэхүүн хэсэг болох эдийн засгийн хавчлагын эсрэг чиглэгдэж байжээ.

Манжийн ноёрхлын үед ч гэсэн Цагаан хэрэм Монгол, Хятад орнуудыг заагласан хэвээр байсан буюу тэр үеийн хуульд Хятад хүн Цагаан хэрмээс хойш гарч болохгүй гэж заасан байдаг юм.

² Сыма Цянь. «Исторические записки» пер. с. кит. Р. В. Вяткина и В. С. Таскина. М., 1975 том 2. Бань Гу. Ханьшу.

³ Бань гу, Ханьшу (Хан улсын судар) 94-р бүлэг, 24-р тал.

⁴ Материалы по истории Сяунну. Перевод и коминтари. В. С. Таскина М., 1968. с. 47-48.

Цагаан хэрэм нь олон тооны цамхаг, бэхлэлтэй юм. Эдгээр цамхагуудаас нэрд гарсан нь Цзюйюнгуань цайз (Цавчаал боомт) Бээжин хотын Чанпинсяний районд байдаг. Цагаан хэрэмний хамгийн том боомт хаалга нь Цавчаал боомт бөгөөд эрт дээр үед Бээжин хотын баруун хойт талын хэрмэн хамгаалалт байжээ. Цавчаал боомтын нэг хэсэг болох Юнтай хэмээх цайзыг 1345 онд барьжээ. Түүний тавцан дээр бурхны шашны гурван суваг байв. Тавцанг гантиг чулуугаар хийжээ. Өндрөөрөө 9,5 м, доод суурь нь 26,84х 17,54 метр ажээ. Юнтай цайзны дээд хэсэг нь дөрвөн талаасаа чулуун хамгаалалтай, ус урсгах гоожууртай баригджээ. Цайзны дунд хэсэгт өмнө хойт зүг рүү харсан гулдан хаалгатай. Хаалгыг таван өнцөг гарган хийсэн бөгөөд хэмжээний хувьд морь уналга морин тэрэг нэвтрэх боломжтой ажээ. Цагаан хэрэмийн хойт зүг рүү гарах нэг боомт хаалга бол Бадалины цайз юм. Тэрхүү цайз нь 1505 онд баригдсан ба трапеци хэлбэртэй. Бадалины цайзтай залгаа хэрмийг уул түшүүлж барьжээ. Хананы дотор тал нь нуувч халхавчаас бүрддэг байна. Уулын хавцалд баригдсан зарим газрыг цайз маягийн тавцантай барьжээ. Дээд давхар нь олон халгавчтай дөрвөлжин тавцантай, доод тал нь олон тооны морьт цэрэг зэвсэгтэйгээ багтан оршдог том хэмжээний сав ажээ. Нам газар баригдсан Цагаан хэрэмийн зарим хэсэг давхар ханан хамгаалалттай юм.

Цагаан хэрэмний нэг том цайз бол Шаньхайгуань юм. Тэр нь Хэбэй мужийн Цинхуандаоши хотоос 15 км оршдог. Шаньхайгуань 1381 онд баригдсан байна. Түүнийг уул далайн хоёрын хооронд байрлуулан барьсан учир уул далайн боомт хаалга «Шаньхайгуань» гэж нэрлэдэг. Шаньхайгуань нь дөрвөн зүгт байрласан цайзаар бүрддэг буюу түүний зүүн хаалгыг «Тянься дии гуань» гэдэг юм. Тэр нь 1381 онд баригдсан бөгөөд Мин улсын үед хойт зүг рүү гарах чухал гарц байжээ. Тянься дии гуань цайз дөрвөлжин хэлбэртэй, өндөр нь 12 метр, өмнө хойт талаасаа цагаан хэрэмтэй залгаатай юм. Тус цайз нь дундаа том хаалгатай тэр нь онгойж хаагддаг байна.«Губэйкоу» бол Цагаан хэрэмний бас нэг гарц бөгөөд Бээжин хотын Миюн сяний районы зүүн хойт талд байрладаг ажээ. Энэ нь эрт дээр үед стратегийн чухал цэг буюу харилцаа холбооны чухал шижим байв.

Цагаан хэрэм бол эрт, дундад үеийн Хятад ба Төв Азийн нүүдэлчин улс түмний хилийн зааг байсан бөгөөд цэрэг стратегийн чухал бэхлэлт боомтын нэг байв. Одоо үед тэр нь хятадын түүх, соёлын сонин чухал дурсгалын нэг болж үлдсэн байна.